



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

Г Нээлттэй цахимаар арилжсан нүүрсний экспортын талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Нээлттэй цахим арилжаагаар экспортод гаргах нүүрсийг гэрээнд тусгагдсан хугацаанд худалдан авагч талд саадгүй хүргэх зорилгоор Гашуунсухайт боомтын тусгай гарцаар нэвтрүүлэх ажлыг 2023 оны 05 дугаар сард багтаан зохион байгуулахыг Монгол Улсын сайд, Бoomтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Хилийн боомтын захиргаа (Б.Батхишиг)-нд тус тус даалгасугай.

2.Нээлттэй цахим арилжаагаар экспортод гаргах ашигт малтмалыг улсын хилээр саадгүй нэвтрүүлэх асуудлаар БНХАУ-ын талтай хамтран ажиллахад дэмжклэг үзүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улсын сайд, Бoomтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга нарт даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР